



ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 06 сарын 15 өдөр

Дугаар А/163

Улаанбаатар хот

Зөвлөлийн бүрэлдэхүүн, журам
шинэчлэн батлах тухай


Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Иргэний нисэхийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.2 дахь хэсэг, 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Чингис хаан” Олон улсын нисэх буудлын нислэг үйлдвэрлэлийн үйл ажиллагаа, багтаамжид нийцүүлэн агаарын тээвэрлэгчдийн хуваарьт нислэгийн цагийн хуваарийг батлахтай холбогдуулан “Цагийн хуваарийн зөвлөл”-ийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, “Нислэгийн цагийн хуваарийг зохицуулах журам”-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2. Журмыг мөрдөж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Агаарын навигаци, нисэх буудлын бодлого зохицуулалтын газар (Ч.Одгэрэл)-т үүрэг болгосугай.


3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2021 оны “Цагийн хуваарийн зөвлөлийг шинэчлэн байгуулах тухай” А/75 дугаар тушаал, 2021 оны “Журам шинэчлэн батлах тухай” А/74 дугаартай тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



С.МӨНХНАСАН

Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын
2022 оны 6 дугаар сарын 6-ний өдрийн
АИ/БЗ дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



Цагийн хуваарийн зөвлөлийн бүрэлдэхүүн

Зөвлөлийн дарга:

Агаарын навигаци, нисэх буудлын бодлого
зохицуулалтын газрын дарга

Гишүүд:

Агаарын тээврийн бодлого, зохицуулалтын
газрын дарга

Иргэний нисэхийн үндэсний төвийн Агаарын
навигацийн үйлчилгээний газрын дарга

Иргэний нисэхийн үндэсний төвийн Нисэх
буудлуудын үйлчилгээний газрын дарга

“Чингис хаан” Олон улсын нисэх буудлын
Гүйцэтгэх захирал (тохиролцсоноор)

“Чингис хаан” Олон улсын нисэх буудлын
Үйл ажиллагаа хариусан захирал
(тохиролцсоноор)

“Чингис хаан” Олон улсын нисэх буудлын
Шуурхай удирдлага, хяналтын төвийн дарга
(тохиролцсоноор)

Нарийн бичгийн
дарга:

Иргэний нисэхийн үндэсний төвийн Нислэгийн
урсгал төлөвлөлтийн албаны дарга

Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын
2022 оны 6 дугаар сарын 15 ний өдрийн
6 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



НИСЛЭГИЙН ЦАГИЙН ХУВААРИЙГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ

1. ЗОРИЛГО
 - 1.1. Олон улсын болон орон нутгийн нисэх буудлуудын багтаамж, үйлдвэрлэл, үйлчилгээний нэвтрэн өнгөрүүлэх хүчин чадал, агаарын тээвэрлэгчдийн тээвэрлэлтийн боломжтой уялдуулан хуваарьт нислэгийн цагийн хуваарийг нэгтгэх, батлах, хэрэгжүүлэх, нэмэлт өөрчлөлт оруулахтай холбогдсон үйл ажиллагааг зохицуулахад уг журмын зорилго оршино.
 - 1.2. Олон улсын агаарын тээвэрлэгчдийн холбооноос хэвлэн гаргасан “Олон улсын нислэгийн цагийн хуваарийг зохицуулах зааварчилгаа” /World Slot Guidelines/-нд үндэслэн боловсруулагдсан болно.
2. ТОДОРХОЙЛОЛТ
 - 2.1. Хуваарьт нислэг гэдэг нь олон нийтэд нээлттэй зарласан цагийн хуваарийн дагуу тогтмол давтамжтайгаар үйлдэх нислэгийг хэлнэ.
 - 2.2. Нислэгийн цагийн хуваарийг олон улсын болон орон нутгийн хуваарьт нислэгийн цагийн хуваарь гэж ангилна.
 - 2.3. Олон улсын болон орон нутгийн хуваарьт нислэгийн цагийн хуваарийг тухайн орон нутгийн цагаар тооцно.
 - 2.4. Нэмэгдэл нислэг гэдэг нь хуваарьт нислэгийн цагийн хуваарьт тодорхой хугацаанд нэмэгдэх нислэгийг хэлэх бөгөөд нислэгийн цагийн хуваарийн үргэлжлэх хугацаа 60 хоног байна.
 - 2.5. Олон улсын болон орон нутгийн хуваарьт нислэгийн цагийн хуваарийн улирлыг ОУИНБ /IATA/ -аас тогтоосон хугацаа, журмын дагуу мөрдөнө. Үүнд:
 - 2.5.1. Олон улсын болон орон нутгийн зуны нислэгийн цагийн хуваарийг 3 дугаар сарын сүүлчийн Ням гарагаас 10 дугаар сарын сүүлчийн долоо хоногийн Бямба гарагийг дуустал;
 - 2.5.2. Олон улсын болон орон нутгийн өвлийн нислэгийн цагийн хуваарийг 10 дугаар сарын сүүлчийн Ням гарагаас дараа оны 3 дугаар сарын сүүлчийн долоо хоногийн Бямба гарагийг дуустал.
3. ЦАГИЙН ХУВААРИЙН ЗӨВЛӨЛ
 - 3.1. Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй нисэх буудлуудад нислэг үйлдэх агаарын тээвэрлэгчдийн хуваарьт нислэгийн цагийн хуваарийн төслийг энэхүү журмын дагуу хүлээн авч, Цагийн хуваарийн зөвлөл (цаашид Зөвлөл гэх)-өөр хэлэлцэн батална.
 - 3.2. Зөвлөлийн бүрэлдэхүүнийг Иргэний нисэхийн ерөнхий газар /цаашид ИНЕГ гэх/-ын даргын тушаалаар томилно.
 - 3.3. Зөвлөл нь дараах бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:
 - 3.3.1. Зөвлөлийн дарга бөгөөд Агаарын навигаци, нисэх буудлын бодлого зохицуулалтын газрын дарга;

- 3.3.2. Нарийн бичгийн дарга бөгөөд Иргэний нисэхийн үндэсний төвийн Нислэгийн урсгал төлөвлөлтийн албаны дарга;
- 3.3.3. Гишүүд:
 - 3.3.3.1. Агаарын тээврийн бодлого, зохицуулалтын газрын дарга;
 - 3.3.3.2. Иргэний нисэхийн үндэсний төвийн Агаарын навигацгийн үйлчилгээний газрын дарга;
 - 3.3.3.3. Иргэний нисэхийн үндэсний төвийн Нисэх буудлуудын үйлчилгээний газрын дарга;
 - 3.3.3.4. “Чингис хаан” Олон улсын нисэх буудлын Гүйцэтгэх захирал;
 - 3.3.3.5. “Чингис хаан” Олон улсын нисэх буудлын Үйл ажиллагаа хариуцсан захирал;
 - 3.3.3.6. “Чингис хаан” Олон улсын нисэх буудлын Шуурхай удирдлага, хяналтын төвийн дарга.

4. ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛ

- 4.1. Зөвлөлийн гишүүд нь Олон улсын агаарын тээвэрлэгчдийн холбооноос зохион байгуулдаг цагийн хуваарийн зохицуулах хуралд жилд нэгээс доошгүй удаа оролцоно.
- 4.2. Зөвлөлийн хурлыг жилд 2 удаа зохион байгуулж өвөл, зуны олон улсын болон орон нутгийн хуваарьт нислэгийн цагийн хуваарийг хэлэлцэн батлах бөгөөд шаардлагатай тохиолдолд Зөвлөлийн даргын шийдвэрээр ээлжит бус хурлыг хуралдуулж болно. Үүнд:
 - 4.2.1. Өвлийн хуваарьт нислэгийн цагийн хуваарийг жил бүрийн 9 дүгээр сард,
 - 4.2.2. Зуны хуваарьт нислэгийн цагийн хуваарийг жил бүрийн 2 дугаар сард.
- 4.3. Зөвлөлийн хуралд Агаарын тээвэрлэгчдийн холбоо болон агаарын тээвэрлэгч байгууллагуудыг шаардлагатай тохиолдолд оролцуулж болно.
- 4.4. Зөвлөл нь гадаад болон дотоодын агаарын тээвэрлэгчдийн олон улсын хуваарьт нислэгийн өвөл, зуны цагийн хуваарийн хүсэлтийг зохицуулахдаа нислэгийн цагийн гүйцэтгэл, цагийн хуваарийн тогтмолжилт зэргийг харгалзан үзэж “Нислэгийн цагийн хуваарийг зохицуулах журам”-ыг баримтлан ажиллана.
- 4.5. Зөвлөл нь гадаадын агаарын тээвэрлэгчдийн хуваарьт нислэгийн цагийн хуваарийн төслийг шийдвэрлэхээс өмнө үндэсний агаарын тээвэрлэгчдийн нислэгийн цагийн хуваарийг төлөвлөх, зохицуулах чиглэлийг баримтална.
- 4.6. Зөвлөлийн хурлаар дараах асуудлыг хэлэлцэнэ. Үүнд:
 - 4.6.1. Олон улсын өвөл, зуны хуваарьт нислэгийн цагийн хуваарийг батлах;
 - 4.6.2. Орон нутгийн өвөл, зуны хуваарьт нислэгийн цагийн хуваарийг батлах;
 - 4.6.3. Олон улсын болон орон нутгийн батлагдсан хуваарьт нислэгийн цагийн хуваарьт 5 буюу түүнээс дээш тогтмол шинжтэй өөрчлөлт оруулах буюу нэмэгдэл нислэгийн хүсэлтийг хэлэлцэн шийдвэрлэх;
 - 4.6.4. Нисэх буудлын засвар үйлчилгээг хийхтэй холбоотой зохицуулалт хийх;
 - 4.6.5. Байгалийн давагдашгүй хүчин зүйл болон онцгой нөхцөл байдал үүссэний улмаас нисэх буудлуудын үйлчилгээг тодорхой хугацаанд хязгаарлах асуудлыг хэлэлцэх;
 - 4.6.6. Нислэгийн цагийн хуваарийн журамд өөрчлөлт оруулах;
 - 4.6.7. Зөвлөлийн даргын шийдвэрээр яаралтай хэлэлцэх бусад асуудлууд.
- 4.7. Зөвлөлийн гишүүд нь хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд тусгуулах асуудлыг холбогдох тооцоо, судалгаа, шийдвэрийн төсөл, бусад материалын хамт зөвлөлийн нарийн бичгийн даргад хүлээлгэн өгнө.

- 4.8. Зөвлөлийн нарийн бичгийн дарга нь хурлаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг хурал болохоос 5 хоногийн өмнө боловсруулж, хэлэлцэх асуудлын танилцуулга, материалын хамт Зөвлөлийн даргад танилцуулж, урьдчилан батлуулсан байна
- 4.9. Зөвлөлийн хурлын хэлэлцэх асуудалд агаарын тээвэрлэгчид олон улсын болон орон нутгийн батлагдсан хуваарьт нислэгийн цагийн хуваарийг хэрхэн мөрдөж ажилласан болон гаргасан зөрчил дутагдлын талаарх тайланг заавал тусгана.
- 4.10. Зөвлөлийн нарийн бичгийн дарга нь зөвлөлийн гишүүн тус бүрт цагийн хуваарийн төслийг танилцуулга, судалгаануудын хамт Зөвлөлийн хурал эхлэхээс 2 хоногийн өмнө цахимаар хүргүүлж, танилцах, судлах боломжоор хангана.
- 4.11. Зөвлөлийн хурлын батлагдсан төлөвлөгөөний дагуу зөвлөлийн гишүүд хариуцсан чиглэлээр танилцуулга хийнэ.
- 4.12. Зөвлөл нь Нарийн бичгийн даргын нэгтгэсэн цагийн хуваарийн төслийг хэлэлцэж, батална.
- 4.13. Зөвлөлийн хуралд хэлэлцэж буй асуудлыг тодруулах, нэмэлт мэдээлэл авах зорилгоор дотоодын агаарын тээвэрлэгч байгууллагуудын удирдах албан тушаалтнууд, гадаадын агаарын тээвэрлэгч байгууллагуудын ерөнхий төлөөлөгч нарыг оролцуулж болно.
- 4.14. Зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудлын хүрээнд төрийн чиг үүргийн байгууллагуудтай харилцан тохиролцож холбогдох зохицуулалтыг хийх зорилгоор хил, гааль, мэргэжлийн хяналт, гадаадын иргэн харьяатын асуудал эрхэлсэн байгууллагын төлөөллийг оролцуулж болно.
- 4.15. Зөвлөлийн нарийн бичгийн дарга нь хурлын тэмдэглэлийг хөтөлж, баримтжуулах ба Зөвлөлийн даргад танилцуулна. Хурлын тэмдэглэлд дараах мэдээллийг бүрэн тусгасан байна. Үүнд:
 - 4.15.1. Хурлыг хаана, хэзээ, ямар бүрэлдэхүүнтэй зохион байгуулсан;
 - 4.15.2. Хэлэлцсэн асуудлууд;
 - 4.15.3. Хэлэлцсэн асуудал тус бүрээр гаргасан шийдвэр.
- 4.16. Зөвлөлийн хурлын шийдвэрийн дагуу олон улсын болон орон нутгийн хуваарьт нислэгийн цагийн хуваарийг Зөвлөлийн нарийн бичгийн дарга ажлын 3 хоногт багтаан журмын Хавсралт 2, Хавсралт 3-ын дагуу батлуулан холбогдох байгууллагуудад хүргүүлнэ.

5. НИСЛЭГИЙН ХУВААРЬ ИРҮҮЛЭХ ХУГАЦАА

- 5.1. Олон улсын болон орон нутгийн хуваарьт нислэгийн цагийн хуваарийн хүсэлтийг улирал эхлэхээс 30 хоногийн өмнө Зөвлөлийн нарийн бичгийн даргад Хавсралт 1-ийн дагуу цахимаар ирүүлнэ.
- 5.2. Олон улсын болон орон нутгийн батлагдсан хуваарьт нислэгийн цагийн хуваарьт 5 буюу түүнээс дээш тогтмол шинжтэй өөрчлөлт оруулах буюу нэмэгдэл нислэгийн хүсэлтийг тухайн нислэг эхлэхээс 14 хоногийн өмнө Зөвлөлийн нарийн бичгийн даргад Хавсралт 1-ийн дагуу цахимаар ирүүлнэ.
- 5.3. Нисэх буудалд засвар үйлчилгээг хийхтэй холбоотой зохицуулалт хийх хүсэлтийг Зөвлөлд тухай бүр ирүүлнэ.
- 5.4. Байгалийн давагдашгүй хүчин зүйл болон онцгой нөхцөл байдал үүссэний улмаас нисэх буудлуудын үйлчилгээг тодорхой хугацаанд хязгаарлах тохиолдолд хүсэлтийг Зөвлөлд тухай бүр ирүүлнэ.

6. ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

- 6.1. Зөвлөлийн шийдвэрийг зөрчсөн агаарын тээвэрлэгч байгууллагын хуваарьт нислэгийн цагийн хуваарийг хуваарьт бус нислэг болгон өөрчлөх буюу хуваарьт нислэгийн цагийн хуваарийг цуцлах хүртэл арга хэмжээ авна.

- 6.2. Зөвлөлөөр батлагдсан олон улсын болон орон нутгийн өвөл, зуны хуваарьт нислэгийн цагийн хуваарийн дагуу 60 хоногийн хугацаанд нислэг үйлдээгүй агаарын тээвэрлэгчийн батлагдсан хуваарьт нислэгийн цагийн хуваарийг мэдэгдэл өгөхгүйгээр шууд цуцална.
- 6.3. Агаарын тээвэрлэгчийн хуваарьт нислэгийн цагийн хуваарь тогтмолжоогүй, эсхүл хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр чиглэл өөрчлөх, цуцлах, саатсан нислэгийн тоо тухайн чиглэлийн нийт нислэгийн 30 хувиас хэтэрсэн тохиолдолд дараагийн улирлын хуваарьт нислэгийн цагийн хуваарьт тухайн чиглэлийн нислэгийг оруулахгүй буюу хуваарьт бус болон нэмэгдэл нислэгийн цагийн хуваарьт хязгаарлалт хийж болно.



APPROVED BY

_____ AIRLINES INTERNATIONAL FLIGHT SCHEDULE
20 ... year (winter /summer)

No	Flight number	Aircraft type	Destination	Flight days	Departure time	Arrival time	Effective date

/Local time/

БАТЛАВ

_____ АГААРЫН ТЭЭВЭРЛЭГЧИЙН
ОРОН НУТГИЙН ХУВААРЬТ НИСЛЭГИЙН ЦАГИЙН ХУВААРЬ
20 ... оны өвөл/зуны

№	Аяллын дугаар	Агаарын хөлгийн маяг	Чиглэл	Гараг	Нисэх цаг	Буух цаг	Хүчинтэй хугацаа

/Орон нутгийн цагаар/

БАТЛАВ:
ЦАГИЙН ХУВААРИЙН ЗӨВЛӨЛИЙН
ДАРГА

20 ... ОНЫ ЗУНЫ/ӨВЛИЙН ОРОН НУТГИЙН ХУВААРЬТ НИСЛЭГИЙН ЦАГИЙН ХУВААРЬ
(МӨРДӨХ ХУГАЦАА 20 ... ОНЫ ... ДУГААР САРЫН ... НААС 20 ... ОНЫ ... ДУГААР САРЫН ... НЫ ӨДӨР ХҮРТЭЛ)

Агаарын тээвэрлэгч, Агаарын хөлийн маяг	Аяллын дугаар	Нислэгийн чиглэл	ДАВАА		МЯГМАР		ЛХАГВА		ПҮРЭВ		БААСАН		БЯМБА		НЯМ		Хүчинтэй хугацаа	
			Нисэх	Буух	Нисэх	Буух	Нисэх	Буух	Нисэх	Буух	Нисэх	Буух	Нисэх	Буух	Нисэх	Буух		

/Орон нутгийн цагаар/

ТАНИЛЦСАН:

НЭГТГЭСЭН:

ХАВСРАЛТ 3

БАТЛАВ,
ЦАГИЙН ХУВААРИЙН ЗӨВЛӨЛИЙН
ДАРГА

20 ... ОНЫ ЗУНЫ/ӨВЛИЙН ОЛОН УЛСЫН ХУВААРЫТ НИСЛЭГИЙН ЦАГИЙН ХУВААРЬ
(МӨРДӨХ ХУГАЦАА 20 ... ОНЫ ... ДУГААР САРЫН ... НААС 20 ... ОНЫ ... ДУГААР САРЫН ... НЫ ӨДӨР ХҮРТЭЛ)

Агаарын тээвэрлэгч, Агаарын хөлгийн маяг	Аяллын дугаар	Нислэгийн чиглэл	ДАВАА		МЯГМАР		ЛХАГВА		ПҮРЭВ		БААСАН		БЯМБА		НЯМ		Хүчинтэй хугацаа
			Нисэх	Буух	Нисэх	Буух	Нисэх	Буух	Нисэх	Буух	Нисэх	Буух	Нисэх	Буух	Нисэх	Буух	

/Орон нутгийн цагаар/

ТАНИЛЦСАН:

НЭГТГЭСЭН:

НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТИЙН ХУУДАС

Хувилбар	Огноо	Баталгаажуулсан	Тайлбар
1.	2010.06.11	Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын А/210 дугаар тушаал	“Нислэгийн цагийн хуваарийг зохицуулах журам”-ыг шинээр баталсан
2.	2017.02.24	Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын А/126 дугаар тушаал	“Нислэгийн цагийн хуваарийг зохицуулах журам”-ын нэмэлт, өөрчлөлтийг баталсан.
3.	2019.10.08	Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын А/819 дугаар тушаал	“Нислэгийн цагийн хуваарийг зохицуулах журам”-ыг шинэчлэн баталсан.
4.	2021.06.29	Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын А/74 дүгээр тушаал	“Нислэгийн цагийн хуваарийг зохицуулах журам”-ыг шинэчлэн баталсан.